



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 459

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/207 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 15,180,000.00 (арван таван сая нэг зуун наян мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Н.Нандинболор, Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Серик нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002247

22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дүгээр сарын 16 ны өдрийн
17 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАРТ ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон, бүртгэсэн он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин, Фургон, 48-10 БӨТ	2013/2024	ш	1	10,000,000.00
2	Хүлэмж (8*10)	2024	ш	1	5,180,000.00
	Нийт дүн				15,180,000.00 (арван таван сая нэг зуун наян мянга)